

# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажилд гүйцэтгэгч сонгон шалгаруулах тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Цалин хөлсний бүтцийн судалгааны хүрээнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын цалин, цалингийн бүтцийг судлан тодорхойлох мэдээллийг захиалагчаас боловсруулсан судалгааны арга, арга зүйн дагуу мэдээлэл цуглуулах, мэдээллийн бааз үүсгэх ажлыг 2-3 сарын хугацаанд гүйцэтгэх болно.
3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.
  - Судалгаа, шинжилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
  - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй;
  - Хөдөлмөрийн харилцааны асуудлын хүрээнд судалгааны ажил хийсэн;
  - Мэдээлэл цуглуулах хангалттай туршлагатай, ажиллах хүчний нөөцтэй;
  - Судалгааны багийн ахлах, голлох мэргэжилтнүүд нь хөдөлмөрийн харилцааны асуудлыг ойлгох, оношлох мэдлэг, туршлагатай, эдийн засаг, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн байх;
  - Татвар болон нийгмийн даатгалын байгууллагад өр төлбөргүй байх. /тодорхойлолт ирүүлэх/
4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.
5. Сонирхсон этгээд мэдүүлгээ **2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 4 дүгээр сарын 24-ний өдрүүдэд 09.00-17.00 цагийн** хооронд дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө,  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын байр, 5 дугаар давхар,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт  
Утас 77121286